



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар A/01

Сүхбаатар сум

### 2021 оныг "Чанарыг эрхэмлэх жил" болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 5.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2021 оныг "Чанарыг эрхэмлэх жил" болгон зарласугай.

2.Зарласан жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх шатны төр, төсвийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарч, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төр, төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Зарласан жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/, иргэд, олон нийтэд мэдээлж, сурталчилж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Лувсандагва/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ